

Газ гэнэт асахгүй болбол!

▼Эхлээд газ асахгүй байгаа шалтгаан болон аюулгүй байдлыг шалгаарай.

Газ ашиглаж байх үед 5 ба түүнээс дээш баллын газар хөдлөлт болсон тохиолдол

Газан төхөөрөмжийг унтраахаа мартах зэрэг газ олон цагаар ашиглагдаж буй тохиолдол

Газны хоолой мултрах зэрэг газ их хэмжээгээр алдаж буй тохиолдол

Харагдах дэлгэц

Тохиргоог шинэчлэх товчлуур

▼Газны тоолуурын тохиргоог шинэчлэх арга

1

- Төхөөрөмжийн хаалтыг **бүгдийг хаана** уу.
- Ашиглаагүй газны гол хаалт хаалттай байгаа эсэхийг шалгана уу.

2

- Зүүн талын тохиргоог шинэчлэх товчлуурыг дарна уу.
- “**ガス止** (Газ хаах)” гэсэн бичиг арилна.

3

- Дэлгэц дээрх үсэг болон гэрэл анивчина.
- 1 минут орчим** хүлээнэ үү.
- * Гэрэл нь тохиргоог шинэчлэх товчлуурын хэсэгт байрлаж болно.

4


- Дэлгэц дээрх үсэг болон гэрэл унтарна.
- Тохиргоог шинэчлэх үйлдэл дуусна.
- Газ ашиглаж болно.

Газ алдагдах, газ үнэртэх үед тохиргоог шинэчлэх үйлдлийг хийлгүй, LP газны компани эсвэл ослын дуудлагын утас руу холбоо барина уу.

* Газ ашиглаагүй үед газыг хаахгүй байх горимд шилжсэн байдаг.
* Тохиргоог шинэчилсэн ч (тохиргоо шинэчлэгдэхгүй) байх тохиолдолд энэ үйлдлийг давтан хийлгүй LP газны компаниар шалгуулна уу.

Газан төхөөрөмж 10 жил болсон бол үзлэг хийлгүүлье.

Удаан ашиглаж буй газан төхөөрөмж нь эд анги зэрэг элэгдэж муудсанаас осол аваар үүсэх эрсдэлтэй. 10 жил болсон бол үйлдвэрлэгч эсвэл газан төхөөрөмжийн борлуулагч руу үзлэг хийлгэх хүсэлт өгнө үү.



Газан төхөөрөмжийн жишээ

LP газны ослын дуудлагын утас	LP газны компанийн нэр
Холбоо барих хаяг:	
Утас:	
Ослын дуудлагын утас 24 цагаар ажилладаг.	

LP газны аюулгүй байдлын зөвлөлийн вэб хуудсаар ч дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

<http://www.lpg.or.jp/>

LPガス安全委員会
2024.8(モンゴル語)

Ахуйн LP газны аюулгүйн зааварчилгаа

Аюулгүй, найдвартай ашиглахын тулд

Гал тогоо, зочны өрөө зэрэг гэр бүлийн гишүүдийн нүдэнд тусах газар байрлуулна уу.

! Газ үнэртэж байгааг мэдэрвэл, Тийм үед авах арга хэмжээ нь!

✓ Гал ашиглаж огт болохгүй.

Гал гаргахыг хатуу хориглоно

- Гал авалцах шалтгаан болох учир гал гаргахгүй, мөн агааржуулалтын сэнс болон гэрлийн унтраалгад ч огт болохгүй.

✓ Хаалга, цонхоо том онгойлгож, газыг гадагшлуулаарай.

- LP газ нь агаараас хүнд учир нам доор газарт хуримтлагдаж үлддэгийг анхаарна уу.

✓ Бүх төхөөрөмжийн хаалт, газны гол хаалтыг хаагаарай.

Нар зөв

Хаах

Хаах

- Тоолуурын газны хаалт эсвэл баллоны хаалтыг заавал хаана уу.

✓ Газ алдагдаж буй нөхцөл байдлыг шууд мэдээлнэ үү.

“Ослын дуудлагын утас”-ны зааврыг дагаж мөрдөнө үү.

- Оюулгүй байдлыг шалгаж дуусах хүртэл газыг ашиглаж болохгүй.

○ Ослын дуудлагын утсыг LP газны компаниас урьдчилан лавлана уу.


○ Ослын дуудлагын утас 24 цагаар ажилладаг.

LP газны аюулгүй байдлын зөвлөл / Эдийн Засаг, Аж Үйлдвэрийн Яам

СО хордлогод орох ослоос сэргийлэхийн тулд!


✓ Агааржуулалтыг шалгах

- Газ хэрэглэхдээ агаарын солилцоо хийж хэвших




✓ Гадна агааржуулалтын систем бүхий шатаах төхөөрөмж

- Агааржуулалтын хоолой мултраагүй эсэх!
- Агааржуулалтын хоолойн амсар бөглөрөөгүй эсэх эсэх!
- Агааржуулалтын хоолойны үзүүр гадна хананаас цухуйсан эсэх!



Тосон болон газан сэнсэн халаагч хэрэглэж буй хүмүүст

Цагт 1~2 удаа цонхоо онгойлгож агааржуулалт хийнэ үү.



Газ алдагдахаас сэргийлэхийн тулд!


✓ Гал ноцсон эсэхийг шалгах

✓ Дутуу ноцож унтрах

✓ Дахиж даран, галыг ахин ноцоох


- Гал ноцсон эсэхийг шалгаагүйгээс үүдсэн осол гарсаар байна. Заавал нүдээрээ шалгах!
- Ахин дахин ноцоосноор, төхөөрөмжид хуримтлагдсан газнаас гал авалцах осол мөн гардаг. Дахин ноцоохдоо анхааралтай байна уу!

* Анхаар: батерей дууссан үед гал ноцохгүй.




✓ Ашиглахгүй газны гол хаалт нь

- Хаалтын чих "хаах" дээр байгаа эсэх!
- Газны гол хаалтын резин таг таглаатай байгаа эсэх!



✓ Резин хоолой (резин гуурс) нь

- Шатсан, цуурал үүсээгүй эсэх!
- Газны гол хаалт дахь улаан зураас хүртэл угласан байгаа эсэх!
- Даравчаар найдвартай тогтоосон эсэх!



Даравч (хомут)

Аюулгүй байдлыг шалгах!

СО (нүүрс төрөгчийн дутуу исэл)-ийн хордлогын тухай!

Галын төхөөрөмжийг агаар (хүчилтөрөгч)-ын дутмаг байдалд ашигласнаар дутуу шаталт үүсэж, СО (нүүрс төрөгчийн дутуу исэл) ялгардаг. СО нь маш хортой бодис бөгөөд бага хэмжээгээр амьсгалах төдийд л толгой өвдөн дотор муухайрч, нэг мэдэхэд хөдөлж чадахгүй болж үхэлд хүргэх аюултай. СО мэдрэгч тавихыг зөвлөж байна.

Болзошгүй ...-ын тулд!

✓ СО (нүүрс төрөгчийн дутуу исэл) мэдрэгч

✓ Газ мэдрэгч

- Тоос сорогч зэргийг ажиллуулсны дараа буцааж яг залгасан эсэх!
- Залгуур хөндийрөөгүй эсэх!




Газ мэдрэгч болон СО мэдрэгч суурилуулснаар газны аюулыг дохио болон дуут дохиоллоор анхааруулах тул найдвартай.

* Анхаар: Мэдрэгчийг 5 ЖИЛД НЭГ УДАА СОЛИХ шаардлагатай.

✓ LP газны сав нь

- Гал гаргах зүйлийг 2 метрээс ойргүй!



✓ Цасны аюулаас урьдчилан сэргийлэх нь

- Цаснаас үүдэн тохируулагч төхөөрөмж болон газны тоолуур эвдрэх эрсдэлтэй. Цаснаас хамгаалах хаалт болон хайрцагны бүрэн бүтэн байдлыг шалгаж байна уу.
- Цас цэвэрлэхдээ LP газны төхөөрөмжийг гэмтээхээс болгоомжилно уу.



Ийм үед шууд холбогдоорой!

Дөл

Дөл тогтворгүй

Дөл шар өнгөтэй

Дөлгүй хэсэг байх

Ажиллагаа

Ашиглаж байхад унтрах

Хүчтэй авалцаж асах

Гал жигд тархан асахгүй байх

Асахдаа муу байх

Асахгүй байх

Тоног төхөөрөмж

Хачин дуу гарч шатах

Газны үнэр үнэртэх

Ажиллаж байх үед угаарын хийн үнэр үнэртэх

Төхөөрөмж үйлдвэрлэгч эсвэл LP газны компанид шууд шалгуулах хүсэлт өгнө үү.